

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлэх, тэтгэврийн хуримтлал үүсгэх, тэтгэврийн хуримтлалаас хөрөнгө оруулалт хийх, тэтгэвэр олгох, өвлүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хяналт тавих, талуудын эрх ашгийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль тогтоомж

2.1.Хувийн нэмэлт тэтгэврийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль³, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль⁴, Даатгалын тухай хууль⁵, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль⁶, Татварын ерөнхий хууль⁷, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль⁸, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль⁹, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль¹⁰, Компанийн тухай хууль¹¹, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль¹², Хөдөлмөрийн тухай хууль¹³, Нийгмийн даатгалын ерөнхий хууль¹⁴, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль¹⁵, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

¹ Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

² Иргэний хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

³ Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2005 оны 46 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2013 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Даатгалын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2004 оны 20 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2013 оны 41 дугаарт нийтлэгдсэн.

⁷ Татварын ерөнхий хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2019 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

⁸ Хувь хүний орлогын албан татварын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2019 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

⁹ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2019 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

¹⁰ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2015 оны 29 дугаарт нийтлэгдсэн.

¹¹ Компанийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2015 оны 29 дугаарт нийтлэгдсэн.

¹² Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

¹³ Хөдөлмөрийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2021 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

¹⁴ Нийгмийн даатгалын ерөнхий хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2023 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

¹⁵ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2023 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

3.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч болон гишүүн, эрх залгамжлагч, өвлөгч нарын хооронд үүсэх харилцааг энэ хууль болон Даатгалын тухай хууль, Иргэний хууль, холбогдох бусад хуулиар зохицуулна.

3.2.Ажил олгогч, ажилтны хооронд үүсэх хувийн нэмэлт тэтгэврийн шимтгэл төлөхтэй холбогдсон харилцааг энэ хууль болон Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна.

3.3.Хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаанд төрөөс тавих хяналт, зохицуулалттай холбогдсон харилцааг энэ хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох бусад хуулиар зохицуулна.

3.4.Хувийн нэмэлт тэтгэврийн харилцаатай холбогдсон кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагааг энэ хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар тус тус зохицуулна.

3.5.Хувийн нэмэлт тэтгэвэртэй холбогдох татварын харилцааг татварын хууль тогтоомжоор зохицуулна.

3.6.Энэ хууль Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлд заасан даатгалын харилцаанд үйлчлэхгүй.

4 дүгээр зүйл.Хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

4.1.Хувийн нэмэлт тэтгэвэр /цаашид “нэмэлт тэтгэвэр” гэх/-ийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

4.1.1.сайн дурын байх;

4.1.2.шимтгэлд суурилсан, бүрэн хуримтлалын байх;

4.1.3.үйл ажиллагаа, засаглал ил тод байх;

4.1.4.санхүүгийн тогтвортой, бие даасан, найдвартай байдлыг хангасан байх;

4.1.5.өвлөгддөг байх.

4.2.Нийгмийн даатгалын санд шимтгэл төлж, даатгуулсан иргэн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт сайн дурын үндсэн дээр хамрагдаж, нэмэлт тэтгэвэр авч болно.

5 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1.“ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр” гэж ажил олгогч, ажилтан хамтран шимтгэл төлж хамрагдах энэ хуулийн 5.1.3-д заасан үйлчилгээг;

5.1.2.“хувь хүний нэмэлт тэтгэврийн хөтөлбөр” гэж хувь хүн шимтгэл төлж хамрагдах энэ хуулийн 5.1.3-д заасан үйлчилгээг;

5.1.3. “хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр” гэж хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчаас гишүүнд хувийн нэмэлт тэтгэвэр олгох зорилгоор хувь хүн, ажил олгогчтой тохиролцсоны дагуу тэдгээрт үзүүлэх үйлчилгээг;

5.1.4. “шимтгэл” гэж нэмэлт тэтгэвэр авах зорилгоор хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид гишүүний нэр дээр төлсөн мөнгөн хөрөнгийг;

5.1.5. “хувийн тэтгэврийн сан” гэж энэ хуулийн 5.1.3-т заасан үйлчилгээг эрхлэх этгээдийг;

5.1.6. “урт хугацааны даатгагч” гэж энэ хуулийн 5.1.3-т заасан үйлчилгээ эрхлэх урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компанийг;

5.1.7. “гишүүн” гэж энэ хуулийн 6.2-т заасан нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан хүнийг;

5.1.8. “өвлөгч” гэж Иргэний хуулийн 520, 522 дугаар зүйлд заасан этгээдийг;

5.1.9. “эрх залгамжлагч” гэж нас барсан гишүүний хадгалагдсан эрх, нэмэлт тэтгэврийн хөрөнгийг шилжүүлэн авах гишүүний нэрлэсэн хүнийг;

5.1.10. “хадгалагдсан эрх” гэж шилжүүлэх, барьцаалах, хурааж авах, хүчингүй болгох эрхгүй, гишүүний нэмэлт тэтгэврийн хөрөнгө эзэмших хөрөнгийг өмчлөх эрхийг;

5.1.11. “хувийн нэмэлт тэтгэвэр” гэж хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн дагуу гишүүнд олгох мөнгөн хөрөнгийг;

5.1.12. “нэмэлт тэтгэврийн хөрөнгө” гэж гишүүний нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд хуримтлагдсан нийт мөнгөн хөрөнгийг;

5.1.13. “нэмэлт тэтгэврийн журам” гэж шимтгэл төлөх, өгөөж тооцох, олгох, нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хооронд шилжих, гишүүний эрх үүрэг болон тэтгэвэр авах нөхцөл, болзлыг тодорхойлсон баримт бичгийг;

5.1.14. “нэмэлт тэтгэврийн нэрийн данс” гэж хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчаас гишүүний нэр дээр бүртгэсэн нийт шимтгэл, баталгаат өгөөж, баталгаат өгөөжөөс давсан өгөөж, зарлагыг тусгасан мөнгөн хуримтлалын бүртгэлийг;

5.1.15. “баталгаат өгөөж” гэж хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь гишүүний төлсөн нийт шимтгэлээс гэрээнд заасан хугацаа, хувиар тооцож, нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд бүртгэж, нэмэлт тэтгэврийн хөрөнгөд төлөх үнийг;

5.1.16. “итгэмжлэгдсэн өмчлөгч” гэж хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, татан буулгах комиссыг;

5.1.17. “кастодиан” гэж Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 4.1.12-т заасан хуулийн этгээдийг;

5.1.18. “хөрөнгө оруулалтын менежментийн компани” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.33-т заасан хуулийн этгээдийг;

5.1.19. “нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-д заасан иргэн, хуулийн этгээдийг;

5.1.20. “холбогдох этгээд” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.30-д заасан этгээдийг;

5.1.21. “тохиромжтой этгээд” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 68.1-д заасан шалгуурыг хангасан этгээдийг;

5.1.22. “эрх бүхий албан тушаалтан” гэж Компанийн тухай хуулийн 84.1-д заасан этгээдийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ХӨТӨЛБӨР, НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ГЭРЭЭ, ШИМТГЭЛ ТӨЛӨХ, НЭРИЙН ДАНС

6 дугаар зүйл. Хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр

6.1. Хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр /цаашид “нэмэлт тэтгэврийн хөтөлбөр” гэх/ нь хугацаагүй байх бөгөөд гишүүн нэмэлт тэтгэвэр авахад зориулагдана.

6.2. Нэмэлт тэтгэврийн хөтөлбөр нь дараах төрөлтэй байна:

6.2.1. хувь хүний;

6.2.2. ажил олгогчийн.

6.3. Ажилтан, хувь хүн хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчтай нэмэлт тэтгэврийн гэрээ байгуулж, шимтгэл төлснөөр нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн гишүүн болно.

6.4. Ажил олгогч хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг ажилтанд санал болгож болно.

6.5. Ажил олгогч ажилтанд нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг санал болгохдоо мэдээллийн ил тод байдлыг хангана.

6.6. Ажилтан, хувь хүн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн гишүүн болсноос хойш 30 хоногийн дотор нэмэлт тэтгэврийн гэрээнээс татгалзах эрхтэй. Энэ тохиолдолд гэрээг хүчингүйд тооцож төлсөн шимтгэлийг нь урт хугацааны даатгагч, тэтгэврийн сан ажил олгогч, ажилтан, хувь хүнд буцаан шилжүүлнэ.

6.7. Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдахаас татгалзсан ажилтан нэмэлт тэтгэврийн гэрээ байгуулах хүсэлт дахин гаргах эрхтэй.

7 дугаар зүйл. Нэмэлт тэтгэврийн гэрээ

7.1. Энэ хуулийн 6.3 дахь хэсэгт заасан нэмэлт тэтгэврийн гэрээнд дараах зүйлийг заавал тусгана:

7.1.1. гишүүнээр элсэх нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн нөхцөл;
7.1.2. шимтгэлийн хувь, мөнгөн дүн, төлөх хугацаа;
7.1.3. эрх залгамжлагчийн тухай;
7.1.4. баталгаат өгөөж;
7.1.5. гишүүнд баталгаат өгөөжөөс давсан өгөөжийг олгох нөхцөл;
7.1.6. нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хадгалалт, удирдлага, бусад холбогдох мэдээллийг гишүүнд хүргэх хугацаа, арга хэлбэр;

7.1.7. нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хооронд шилжих, хөтөлбөрийг дуусгавар болгох нөхцөл.

7.2. Ажил олгогч нь ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг ажилтантай тохиролцон сонгож, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчтай холбогдох гэрээ байгуулна.

7.3. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч ажилтан, хувь хүнтэй нэмэлт тэтгэврийн гэрээг бичгээр, хугацаагүй байгуулах бөгөөд талуудын зөвшөөрөлгүйгээр нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

7.4. Нэмэлт тэтгэврийн гэрээнд нэмэлт тэтгэврийн журмыг хавсаргана.

7.5. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн нэмэлт тэтгэврийн гэрээгээр хүлээсэн үүрэг нь гишүүн, эрх залгамжлагч, өвлөгч нэмэлт тэтгэвэр авч дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байна.

7.6. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч гишүүнд эрх залгамжлагчаа нэрлэх боломжийг олгоно. Гишүүн нь эрх залгамжлагчаа өөрчлөх эрхтэй.

7.7. Нэмэлт тэтгэврийн хөтөлбөртэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт шинээр батлагдсан, нэмэлт, өөрчлөлт оруулсан нь гишүүнд давуу байдал бий болгохоор бол гишүүний саналаар гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

8 дугаар зүйл. Шимтгэл төлөх

8.1. Хувь хүний нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан гишүүн шимтгэлийг нэмэлт тэтгэврийн гэрээнд заасан нөхцөлийн дагуу бэлэн бусаар төлнө.

8.2. Нэмэлт тэтгэврийн гэрээний дагуу хувь хүний нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан гишүүний төлөх шимтгэлийг хувь хүн, ажилтан дангаар, ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан гишүүний төлөх шимтгэлийг ажил олгогч, ажилтан гэрээгээр харилцан тохиролцож хамтран төлнө.

8.3. Ажил олгогч, ажилтны төлөх шимтгэлийг цалин хөлсний тодорхой хувиар, эсхүл тогтсон дүнгээр тооцно. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчтай байгуулах ажил олгогчийн гэрээнд гишүүний төлөх шимтгэлийн дүн, хувь хэмжээ, шимтгэл төлөх хугацааг заасан байна.

8.4. Ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан ажилтны сард төлөх нийт шимтгэлийн 50-аас доошгүй хувийг ажил олгогч, үлдэх хэсгийг ажилтан төлнө.

8.5.Ажил олгогч нь ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан ажилтны төлөх шимтгэлийг тухайн ажилтны цалин хөлснөөс суутгаж, ажил олгогчоос төлөх шимтгэлийн хамт хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид тухайн сард нь багтааж бэлэн бусаар төлнө.

8.6.Ажил олгогч нь шимтгэл төлөлтийн тайланг дараа сарын 5-ны өдрийн дотор хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, ажилтанд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

8.7.Ажил олгогч нь өөрийн болон ажилтны төлөх шимтгэлийг энэ хуулийн 8.5-д заасан хугацаанд төлөх үүрэгтэй.

8.8.Гишүүн, ажил олгогчийн төлөх шимтгэлд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахгүй.

8.9.Гишүүн, эрх залгамжлагч, өвлөгч, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч төлөгдөөгүй шимтгэлийг төлүүлэхээр шүүхэд гомдол гаргах эрхтэй.

9 дүгээр зүйл.Нэмэлт тэтгэврийн нэрийн данс

9.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь гишүүн бүрд ажлын гурван өдөрт багтаан нэмэлт тэтгэврийн нэрийн данс нээж, дансны мэдээллийг цахим хэлбэрээр хянах боломжтой нэвтрэх эрх олгоно.

9.2.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь гишүүн, ажил олгогчийн төлсөн шимтгэлийг гишүүний нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд өгөөж, баталгаат өгөөжөөс давсан өгөөжийг сар бүр, энэ хуулийн 11.4 дэх хэсэг, 39.2 дахь хэсэгт заасан зарлагыг тухай бүр бүртгэнэ.

9.3.Ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан гишүүний нэр дээр ажил олгогч, ажилтны төлсөн шимтгэлийг тусад нь бүртгэнэ.

9.4.Баталгаат өгөөжийн жилийн доод хэмжээ нь Төв банк /Монголбанк/-ны бодлогын хүүгээс багагүй байна.

9.5.Гишүүнд хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч энэ хуулийн 9.4-т заасан баталгаат өгөөжийг гэрээнд заасны дагуу төлнө.

9.6.Нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд төлсөн шимтгэлийг бүртгэх, гишүүнд мэдээлэх аргачлалыг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ батална.

10 дугаар зүйл.Зардлын ангилал

10.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг захиргааны болон хөрөнгө оруулалтын гэж ангилна.

10.2.Хороо энэ хуулийн 10.1-д заасан зардлын дээд хувь хэмжээг тогтоож болно.

10.3. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь захиргааны болон хөрөнгө оруулалтын зардлын мэдээллийг нэмэлт тэтгэврийн журамд заавал тусгана.

11 дүгээр зүйл.Нэмэлт тэтгэврийн хөрөнгийн эрх

11.1.Нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд хуримтлагдсан мөнгөн хөрөнгө нь гишүүний өмч байна.

11.2.Гишүүнд нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хэмжээгээр хадгалагдсан эрх үүснэ.

11.3.Гишүүн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн, эсхүл хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, эсхүл нас барсан тохиолдолд эрх залгамжлагч, өвлөгч энэ хуулийн 13.1-д заасан хөрөнгийг захиран зарцуулах эрх үүснэ.

11.4.Энэ хуулийн 11.3-т заасан эрх үүсэхээс өмнө гишүүн эрүүл мэндийн үйлчилгээний зардал, өөрийн болон гэр бүлийн гишүүдийн сургалтын төлбөр, өөрийн нэр дээр орон сууц худалдан авах нөхцөлөөр нэмэлт тэтгэврийн хөрөнгийн 30 хүртэл хувийг зарцуулах хүсэлтийг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид нэг удаа гаргаж болно.

11.5.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч энэ хуулийн 11.4-т заасан хүсэлтийг 30 хоногийн дотор шийдвэрлэж, зардал, төлбөрийг тухайн эрүүл мэнд, боловсролын байгууллага, орон сууц худалдагчийн дансанд бэлэн бусаар шилжүүлнэ.

11.6.Нэмэлт тэтгэврийн хөрөнгөөс гишүүний эрүүл мэндийн үйлчилгээний зардал, сургалтын төлбөр, орон сууц худалдан авах төлбөрт зарцуулах хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх, шилжүүлэх, бүртгэх, тайлагнах журмыг Хороо батална.

11.7.Гишүүн, ажил олгогч, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн болон бусад этгээдийн эсрэг үүссэн шаардах эрхийг хангах зорилгоор гишүүний нэмэлт тэтгэврийн хөрөнгийг барьцаалах, битүүмжлэх, суутган авах, шилжүүлэх болон бусад байдлаар захиран зарцуулахгүй.

11.8.Нэмэлт тэтгэврийн нэрийн данс дахь нэмэлт тэтгэврийн хөрөнгө нь гишүүн, ажил олгогч, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компани болон бусад этгээдтэй холбоотой аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шийдвэр гүйцэтгэл, дампуурлын хэрэг, эвлэрэл, түүнтэй адилтгах бусад ажиллагаанд хамаарахгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХУВИЙН ТЭТГЭВРИЙН САН, УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧ

12 дугаар зүйл.Хувийн тэтгэврийн санг үүсгэн байгуулах, нэр, дүрэм

12.1.Хувийн тэтгэврийн санг Компанийн тухай хуулийн дагуу Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулна.

12.2.Хувийн тэтгэврийн санг хэд хэдэн этгээд хувь нийлүүлэн үүсгэн байгуулах бөгөөд нэг үүсгэн байгуулагчийн эзэмших хувь 20 хувиас ихгүй байна.

12.3.Хувийн тэтгэврийн санг үүсгэн байгуулагч Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

12.3.1.санхүүгийн тайлан, мэдээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тайлагнадаг байх;

12.3.2.төрийн эрх бүхий байгууллагын санхүүгийн хяналт шалгалтад хамрагддаг байх;

12.3.3.санхүүгийн тайлан, мэдээг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, олон улсад нэр хүнд бүхий аудитын байгууллагаар жилд нэгээс доошгүй удаа баталгаажуулдаг байх;

12.3.4.хувийн тэтгэврийн сангийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгө нь тухайн этгээд, түүнтэй холбогдох этгээдийн санхүүгийн тайлангаар тодорхойлогдсон, хууль ёсны орлого байх;

12.3.5.хувийн тэтгэврийн сангийн хувь нийлүүлсэн хөрөнгийг зээлийн хөрөнгөөр бүрдүүлээгүй байх;

12.3.6.хувь нийлүүлсэн хөрөнгийг Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан банканд байршуулсан байх;

12.3.7.татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөрийн өргүй байх.

12.4.Хувийн тэтгэврийн сангийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 20 тэрбум төгрөг байна. Энэхүү хэмжээг эдийн засгийн байдал, мөнгөний ханшны өөрчлөлт, хувийн тэтгэврийн санд төвлөрүүлсэн нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хэмжээ, төлбөрийн чадварын эрсдэлийг харгалзан Хороо тухай бүрд нэмэгдүүлэн тогтооно.

12.5.Энэ хуулийн 12.1-д заасан этгээд нь хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаанаас өөр чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

12.6.Хувийн тэтгэврийн сангийн нэр нь түүний оноосон нэр болон “Хувийн тэтгэврийн сан” гэсэн дэлгэрэнгүй тэмдэглэгээ, “ХТС” гэсэн товчилсон тэмдэглэгээнээс бүрдэнэ.

12.7.Энэ хуулийн 12.1-д зааснаас бусад этгээд хувийн тэтгэврийн сангийн дэлгэрэнгүй болон товчилсон тэмдэглэгээг хэрэглэхийг хориглоно.

12.8.Хувийн тэтгэврийн сангийн дүрэмд Компанийн тухай хуулийн 16.2-т зааснаас гадна дараах зүйлийг тусгана:

12.8.1.хувийн тэтгэврийн сан хугацаагүй үүсгэн байгуулагдсан тухай;

12.8.2.удирдлага, зохион байгуулалтын бүтэц;

12.8.3. хөрөнгө оруулалтын өгөөж баталгаат өгөөжөөс бага бол үүсгэн байгуулагч өөрийн хөрөнгөөс нөхөж олгохтой холбогдсон зохицуулалт.

12.9.Хувийн тэтгэврийн сан дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

12.9.1.нэмэлт тэтгэврийн хөтөлбөр боловсруулж, Хороонд бүртгүүлэх;

12.9.2.нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг олон нийтэд эрх тэгш санал болгож нэмэлт тэтгэврийн журмыг нээлттэй, ил тод байршуулах;

12.9.3.нэмэлт тэтгэврийн гэрээ байгуулах, шимтгэл хүлээн авах;

12.9.4.нэмэлт тэтгэврийн нэрийн данс хөтлөх;

12.9.5.нэмэлт тэтгэврийн хөрөнгийг удирдах хөрөнгө оруулалтын менежментийн компанитай гэрээ байгуулах;

12.9.6.нэмэлт тэтгэврийн хөрөнгийг бүртгэх, хадгалах кастодиантай гэрээ байгуулах;

12.9.7.нэмэлт тэтгэвэр олгох;

12.9.8.үйл ажиллагааг эрх бүхий байгууллага, гишүүдэд ил тод тайлагнах;

12.9.9.нэмэлт тэтгэврийн хөтөлбөр, нэмэлт тэтгэврийн гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад үйл ажиллагаа.

13 дугаар зүйл.Хувийн тэтгэврийн сангийн удирдлага, зохион байгуулалт

13.1.Хувийн тэтгэврийн сан төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “Удирдах зөвлөл” гэх)-тэй байна.

13.2.Удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг сонгох, томилох, бүрэн эрхийг дуусгавар болгох асуудлыг энэ хууль болон Компанийн тухай хууль, хувийн тэтгэврийн сангийн дүрэмд заасны дагуу шийдвэрлэнэ.

13.3.Удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

13.4.Энэ хуулийн 5.1.7-д заасан гишүүний төлөөлөл удирдах зөвлөлийн гуравны нэгээс доошгүй хувь байх бөгөөд олонхын саналыг үндэслэн Удирдах зөвлөлийн гишүүнээр сонгоно.

13.5.Удирдах зөвлөлийн гишүүн энэ хууль болон Компанийн тухай хуульд заасан эрх, үүргийг эдэлнэ.

13.6.Хувийн тэтгэврийн сангийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд зааснаас гадна дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

13.6.1.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

13.6.2.ял шийтгэлгүй байх;

13.6.3.ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаанд харшлахгүй байх;

13.6.4.өмнө удирдаж байсан хуулийн этгээдийг өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас дампууруулаагүй байх;

13.6.5.энэ хуулийн 13.4-т зааснаас бусад Удирдах зөвлөлийн гишүүн нь санхүү, эдийн засаг, хууль, эрх зүй, мэдээллийн технологи, компанийн засаглалын аль нэг чиглэлээр мэргэшсэн байх;

13.6.6.энэ хуулийн 13.4-т зааснаас бусад Удирдах зөвлөлийн гишүүн нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 68.1-д заасан тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх.

13.7.Удирдах зөвлөлийн ээлжит хурлыг улирал тутам, ээлжит бус хурлыг Компанийн тухай хуульд заасны дагуу хуралдуулна.

13.8.Удирдах зөвлөл нь Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дараах эрхтэй байна:

13.8.1.нэмэлт тэтгэврийн шимтгэл хүлээн авах, тэтгэвэр олгох, захиргааны болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөх зорилгоор арилжааны банканд данс нээх зөвшөөрөл олгох;

13.8.2.хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодианыг сонгох;

13.8.3.хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан, нягтлан бодох, аудит, хууль зүйн үйлчилгээ үзүүлэгч болон хувийн тэтгэврийн санд үйлчилгээ үзүүлж байгаа бусад этгээдтэй гэрээ байгуулах зөвшөөрөл олгох;

13.8.4.хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан, бусад үйлчилгээ үзүүлэгчээс хувийн тэтгэврийн сангийн нэрийн өмнөөс хийсэн бүх хэлцэл болон хувийн тэтгэврийн сангийн эзэмшиж буй байгаа хувьцааны санал өгөх эрхийг хэрэгжүүлсэнтэй холбогдох мэдээлэлтэй танилцах, хяналт тавих;

13.8.5.нэмэлт тэтгэврийн хөтөлбөр бүрийн хөрөнгө оруулалтын болон эрсдэлийн удирдлагын бодлогыг батлах;

13.8.6.хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан, хувийн тэтгэврийн санд үйлчилгээ үзүүлж байгаа бусад этгээдийн үйлчилгээг дуусгавар болгох, өөрчлөх;

13.8.7.гүйцэтгэх удирдлагын бүтцийг батлах, томилох, цалин хөлс олгох журмыг батлах;

13.8.9.нэмэлт тэтгэврийн журам батлах;

13.8.10.хувийн тэтгэврийн сан, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг дуусгавар болгох.

14 дүгээр зүйл.Хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох

14.1.Хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэх, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих чиг үүргийг Хороо хэрэгжүүлнэ.

14.2.Зөвшөөрөл хүсэгч хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг дараах баримт бичгийн хамт Хороонд цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргана:

14.2.1.хуулийн этгээдийн гэрчилгээ, дүрэм, хувийн тэтгэврийн сангийн дүрэм;

14.2.2.хувийн тэтгэврийн сангийн холбогдох этгээд, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл;

14.2.3.хувийн тэтгэврийн сангийн Удирдах зөвлөлийн гишүүд, тэдгээрийн холбогдох этгээдийн мэдээлэл;

14.2.4.Удирдах зөвлөлийн гишүүдээс итгэмжлэгдсэн өмчлөгчийн үүрэг гүйцэтгэхээ хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл;

14.2.5.хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагааны төлөвлөгөө;

14.2.6.нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын болон эрсдэлийн удирдлагын бодлого;

14.2.7.хуульд заасан бусад.

14.3.Энэ хуулийн 14.2.2, 14.2.3-т заасан мэдээлэлд өөрчлөлт орох бүрд Хороонд ажлын таван өдрийн дотор мэдэгдэж, энэ хуульд заасан шаардлагыг биелүүлнэ.

14.4.Хороо нь энэ хуулийн 14.2-т заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 21 өдрийн дотор шаардлагатай нэмэлт мэдээлэл, баримт бичгийг ирүүлэхийг шаардах, тодруулга, тайлбар авах эрхтэй.

14.5.Хороо зөвшөөрөл хүсэгчээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 45 өдрийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

14.6.Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Хороо хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоно.

14.7.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлагыг Хороо батална.

14.8.Хороо дараах тохиолдолд хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

14.8.1.бүрдүүлсэн баримт бичиг нь энэ хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн шаардлага хангаагүй;

14.8.2.бүрдүүлсэн баримт бичигт гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчийн ашиг сонирхлыг зөрчих зохицуулалтыг тусгасан, эсхүл ашиг сонирхлыг хамгаалах

зохицуулалтыг тусгаагүй.

14.9.Хороо энэ хуулийн 14.8-д заасны дагуу хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд үндэслэлийг тусгасан хариуг зөвшөөрөл хүсэгчид Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр хүргүүлнэ.

15 дугаар зүйл.Хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлийг түдгэлзүүлэх, сэргээх

15.1.Хороо дараах үндэслэлээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ:

15.1.1.эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг хоёр болон түүнээс дээш удаа зөрчсөн;

15.1.2.баталгаат өгөөж, эсхүл гэрээгээр тохирсон баталгаат өгөөжөөс давсан дүнг төлөөгүй;

15.1.3.хуульд заасан мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл худал мэдүүлж тайлагнасан;

15.1.4.нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулаагүй нь тогтоогдсон;

15.1.5.зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангахгүй болсон нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;

15.1.6.зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон.

15.2.Хороо энэ хуулийн 15.1-д заасны дагуу түдгэлзүүлсэн бол хувийн тэтгэврийн сан, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын таван өдрийн дотор бичгээр, эсхүл цахимаар мэдэгдэнэ.

15.3.Хувийн тэтгэврийн сан энэ хуулийн 15.2-т заасан мэдэгдлийг хүлээж авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хариу тайлбарыг Хороонд хүргүүлнэ.

15.4.Хороо тайлбарыг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхгүй тухай шийдвэрийн талаар хувийн тэтгэврийн санд ажлын таван өдрийн дотор бичгээр, эсхүл цахимаар мэдэгдэнэ.

15.5.Хороо энэ хуулийн 15.3-т заасан тайлбарыг үндэслэлгүй гэж үзсэн эсхүл хувийн тэтгэврийн сан холбогдох тайлбар болон нотлох баримтыг ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх шийдвэр гаргаж, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай шийдвэрийн талаар хувийн тэтгэврийн сан, харьяалах татварын алба, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын хоёр өдрийн дотор бичгээр, эсхүл цахимаар мэдэгдэнэ.

15.6.Энэ хуулийн 15.5-д заасан үндэслэл, нөхцөл, шаардлага арилсан тохиолдолд Хороо хувийн тэтгэврийн сангийн хүсэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг сэргээж, тухайн шийдвэрийн талаар хувийн тэтгэврийн сан, харьяалах

татварын алба, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын нэг өдрийн дотор бичгээр, эсхүл цахимаар мэдэгдэнэ.

16 дугаар зүйл. Хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

16.1.Хороо дараах үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

16.1.1.хувийн тэтгэврийн сангийн Удирдах зөвлөл уг сангийн үйл ажиллагааг дуусгавар болгох тухай хүсэлтийг энэ хуулийн 5.1.7-д заасан гишүүн болон Хороонд ажлын 90 өдрийн өмнө бичгээр, эсхүл цахимаар хүргүүлсэн;

16.1.2.нэмэлт тэтгэврийн бүх хөтөлбөр Хорооны бүртгэлээс хасагдсан;

16.1.3.энэ хууль болон бусад хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа эрхэлсэн;

16.1.4.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй.

16.2.Хороо зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл байгаа тухай хувийн тэтгэврийн санд ажлын таван өдрийн дотор бичгээр, эсхүл цахимаар мэдэгдэнэ.

16.3.Хувийн тэтгэврийн сан энэ хуулийн 16.2-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбар, холбогдох баримт бичгийг Хороонд ирүүлээгүй, гомдол гаргаагүй, ирүүлсэн тайлбар баримт бичиг шаардлага хангаагүй бол уг хугацаа дууссанаас хойш ажлын 10 өдрийн дотор Хороо зөвшөөрлийг хүчингүй болгоно.

16.4.Хороо энэ хуулийн 16.3-т хэсэгт заасан шийдвэрийг хувийн тэтгэврийн сан, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, харьяалах татварын албанд ажлын нэг өдрийн дотор бичгээр, эсхүл цахимаар мэдэгдэнэ.

16.5.Тусгай зөвшөөрөлгүй этгээд нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаа эрхлэх, сурталчлахыг хориглоно.

16.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч Хороонд бүртгүүлээгүй нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт гишүүн элсүүлэх, шимтгэл цуглуулах, нэмэлт тэтгэвэр амлах, олгох, сурталчлахыг хориглоно.

17 дугаар зүйл.Урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн үйл ажиллагаа эрхлэх

17.1.Урт хугацааны даатгагч нь нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн үйл ажиллагаа эрхэлж болно.

17.2.Урт хугацааны даатгагч нь энэ хуулийн 17.1-д заасан үйл ажиллагааг энэ хууль, Даатгалын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу эрхэлнэ.

17.3.Урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөтөлбөр бүрд нэмэлт тэтгэврийн журам батална.

17.4.Урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөтөлбөр бүрийн нэмэлт тэтгэврийн хөрөнгийг бусад хөрөнгөөс тусгаарлаж, тусдаа дансанд байршуулж, бүртгэнэ.

17.5.Энэ хуулийн 17.4-т заасан хөрөнгийг урт хугацааны даатгагчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас бусад байдлаар болон хөтөлбөрт холбогдохгүй өр төлбөрийг барагдуулахад зарцуулах, батлан даалт гаргах, барьцаалахыг хориглоно.

17.6.Урт хугацааны даатгагч энэ хуулийн 17.4-т заасан хөрөнгийг өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцаж гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчийн эрх ашгийг хамгаална.

17.7.Урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг олон нийтэд эрх тэгш санал болгож, нэмэлт тэтгэврийн журмыг нээлттэй, ил тод байршуулна.

17.8.Урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын болон эрсдэлийн удирдлагын бодлого батална.

18 дугаар зүйл.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгүүлэх

18.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгүүлэх тухай хүсэлтийг дараах баримт бичгийн хамт Хороонд цаасан, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ:

18.1.1.энэ хуулийн 5.1.13-т заасан нэмэлт тэтгэврийн журам;

18.1.2.кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанитай байгуулсан гэрээ;

18.1.3.гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчтэй байгуулах нэмэлт тэтгэврийн гэрээний загвар.

18.2.Хороо нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгүүлэх тухай хүсэлт, баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 20 өдрийн дотор шалган шийдвэрлэж хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид мэдэгдэнэ.

19 дүгээр зүйл.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэлээс хасах

19.1.Хороо дараах тохиолдолд нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлнэ:

19.1.1.баталгаат өгөөж, эсхүл баталгаат өгөөжөөс давсан гэрээгээр тохирсон дүнг төлөөгүй;

19.1.2.энэ хуульд заасан зар сурталчилгааны шаардлагыг зөрчсөн, худал төөрөгдүүлсэн зар сурталчилгаа түгээсэн;

19.1.3.нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулаагүй зөрчил гаргасан нь тогтоогдсон;

19.1.4. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн.

19.2. Энэ хуулийн 19.1-д заасан үндэслэл байгаа тухай Хороо тогтоосноос хойш хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын таван өдрийн дотор албан бичгээр мэдэгдэнэ.

19.3. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хариу тайлбарыг Хороонд хүргүүлнэ.

19.4. Хороо тайлбарыг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд түдгэлзүүлэхгүй тухай албан бичгийг ажлын таван өдрийн дотор хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид хүргүүлнэ.

19.5. Хороо үндэслэлгүй гэж үзсэн, эсхүл тайлбар ирүүлээгүй бол нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг нэг сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх шийдвэр гаргаж, хөтөлбөрийг түдгэлзүүлсэн тухай шийдвэрийн талаар хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын хоёр өдрийн дотор бичгээр, эсхүл цахимаар мэдэгдэнэ.

19.6. Энэ хуулийн 19.1-д заасан үндэслэл арилсан тохиолдолд Хороо хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн хүсэлтийг үндэслэн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг сэргээнэ.

19.7. Энэ хуулийн 19.1-д заасан шаардлагыг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол Хороо нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэлээс хасна.

19.8. Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэх, түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэлээс хасах журмыг Хороо батална.

20 дугаар зүйл. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг хүчингүй болгох, бүртгэлээс хасах дуусгавар болгох үед авах арга хэмжээ

20.1. Тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, бүртгэлээс хассан, дуусгавар болгосон мэдэгдлийг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь хүлээн авснаас хойш шимтгэл авах, гишүүн элсүүлэхийг хориглоно.

20.2. Хороо энэ хуулийн 20.1-д заасан мэдэгдлийг кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанид мэдэгдэж, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн шилжүүлгийг даруй зогсооно.

20.3. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч үйл ажиллагаа, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг дуусгавар болгох шийдвэр гаргасан бол дараах арга хэмжээг авна:

20.3.1. хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч хөтөлбөрийг дуусгавар болгох тухай мэдэгдэл өгснөөс хойш ажлын 30 өдрийн дотор нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн санхүүгийн тайланг Хороонд хүргүүлж, бүх гишүүдэд мэдэгдэх;

20.3.2. гишүүний хадгалагдсан эрхийн төлбөрийг барагдуулах хөрөнгө хангалттай тохиолдолд нэмэлт тэтгэврийн бусад хөтөлбөрт шилжих боломжийг гишүүнд олгох;

20.3.3. хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөрөнгөнд аудит, актуарын тайлан, дүгнэлт гаргуулах, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр үнэлгээ хийлгүүлэх;

20.3.4. гишүүдийн хадгалагдсан эрхийн төлбөрийг барагдуулах хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч өөрийн хөрөнгөөр барагдуулах тухай хүсэлтийг санхүүгийн тайлангийн хамт Хороонд хүргүүлж, энэ тухай гишүүнд мэдэгдэх;

20.3.5. татан буулгах шийдвэрт ажил олгогчоос төлөгдөөгүй шимтгэлийг энэ хуульд заасны дагуу татан төвлөрүүлэхэд авч хэрэгжүүлсэн бүх арга хэмжээний дэлгэрэнгүй тайланг тусгасан байх;

20.3.6. Хорооноос зөвшөөрсөн тохиолдолд хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн зарим үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.

20.4. Энэ хуулийн 20.3.6-д заасан үйл ажиллагаа татан буулгах явц бүрэн дуусах хүртэл эсхүл актив, пассив нь бусад хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид шилжих хүртэл үргэлжилнэ.

20.5. Тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг Хороо түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, бүртгэлээс хассан тохиолдолд хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь энэ хуулийн 20.3-д заасан арга хэмжээг авна.

20.6. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэлээс хассан тохиолдолд энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

20.7. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн хөрөнгийг буцаан төвлөрүүлэх үйл ажиллагааг зохицуулах журмыг Хороо батална.

21 дүгээр зүйл. Татан буулгах комисс

21.1. Хороо хувийн тэтгэврийн сангийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэлээс хассан тохиолдолд татан буулгах комисс томилно.

21.2. Энэ хуулийн 21.1-д заасан комиссын бүрэлдэхүүнд дараах этгээдийг томилохгүй:

21.1.1. хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн удирдах зөвлөлийн гишүүн, бусад эрх бүхий албан тушаалтан;

21.1.2. хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтан.

21.3.Татан буулгах комисс нь гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчийн өмнө хариуцлага хүлээсэн итгэмжлэгдсэн өмчлөгч байна.

21.4.Татан буулгах комисс, хувийн тэтгэврийн сан Хорооноос урьдчилан зөвшөөрөл авсны үндсэн дээр нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн актив, пассивийг бусад хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид шилжүүлж болно.

21.5.Энэ хуулийн 21.4-т заасан тохиолдолд гишүүдэд 30 хоногийн өмнө мэдэгдлийг бичгээр болон цахимаар хүргүүлж биечлэн уулзалт зохион байгуулж саналыг авна.

21.6.Татан буулгах комисс өр төлбөрийг барагдуулахдаа дараах дарааллыг баримтална:

21.6.1.гишүүдэд олгох бүх өр төлбөр;

21.6.2.хувийн тэтгэврийн сангийн эрх бүхий албан тушаалтнаас бусад ажилтны хуульд заасан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй цалин хөлс, төлөгдөөгүй нийгмийн даатгалын шимтгэл;

21.6.3.албан татвар;

21.6.4.кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйлчилгээний төлбөр;

21.6.5.татан буулгах комиссын үйл ажиллагааны зардал;

21.7. Энэ хуулийн 21.6-д заасан өр төлбөрийг бүрэн барагдуулсны дараа хувийн тэтгэврийн сан, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хөрөнгө үлдсэн бол татан буулгах комисс хөрөнгө хуваарилах төлөвлөгөө боловсруулж, Хороонд батлуулахаар хүргүүлнэ.

21.8.Гишүүн, эрх залгамжлагч, өвлөгч нь татан буулгах комисс, хувийн тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан, тэдгээрийн холбогдох этгээд, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн эсрэг нэхэмжлэл, гомдол гаргах эрхтэй.

21.9.Татан буулгах комиссын бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, сонгон шалгаруулах, өр төлбөр барагдуулах, урамшуулах, бусад харилцааг зохицуулсан журмыг Хороо батална.

21.10.Урт хугацааны даатгагчийг татан буулгахтай холбогдсон харилцааг Даатгалын тухай хуулийн дагуу, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэлээс хассан тохиолдолд энэ хуулийн дагуу зохицуулна.

21.11.Хувийн тэтгэврийн санг татан буулгахтай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Иргэний хууль, Дампуурлын тухай хууль, Компанийн тухай хуулийн дагуу зохицуулна.

22 дугаар зүйл.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн зар сурталчилгаа

22.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг олон нийтэд үнэн зөв, ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр сурталчилна.

22.2.Хорооноос тусгай зөвшөөрөл аваагүй, хороонд нэмэлт тэтгэврийн хөтөлбөрөө бүртгүүлээгүй тохиолдолд “хувийн тэтгэврийн сан”, “урт хугацааны даатгагч”, “нэмэлт тэтгэвэр”, “хувийн тэтгэвэр” гэсэн агуулга бүхий үг хэллэг эсхүл ижил төстэй бүтээгдэхүүнийг зах зээлд олон нийтэд санал болгох, сурталчлахыг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, КАСТОДИАН, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИ

23 дугаар зүйл.Хөрөнгө оруулалт хийх

23.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор энэ хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу хөрөнгө оруулалт хийнэ.

23.2.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч хөрөнгө оруулалт болон бусад асуудлаас үүдэлтэй алдагдлыг өөрийн хөрөнгөөр хариуцаж, гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчийн нэмэлт тэтгэврийн хөрөнгийг хамгаална.

23.3.Хувийн тэтгэврийн сангийн хувь нийлүүлсэн хөрөнгөөр энэ хуулийн 24.1-д заасан зарчмыг баримтлан Хорооноос баталсан журмын дагуу хөрөнгө оруулна.

23.4.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн хөрөнгө оруулалтад тавих нийтлэг шаардлага, зохистой харьцаа, эрсдэлийн удирдлага, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журмыг Хороо батална.

23.5.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч Хорооноос баталсан шаардлагыг хангасан хөрөнгө оруулалт, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын нэгжтэй байна.

24 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалт хийхэд баримтлах зарчим

24.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь хөрөнгө оруулалт хийхэд дараах зарчмыг баримтална:

- 24.1.1.хөрөнгийн аюулгүй байдлыг хангах;
- 24.1.2.хөрөнгө оруулалтыг төрөлжүүлэх,
- 24.1.3.ашгийн дээд хэмжээг эрэлхийлэх;
- 24.1.4.зохистой харьцааг хангах.

25 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг

25.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч энэ хуулийн 24.1-д заасан зарчим, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн дараах агуулгыг тусгасан хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийг боловсруулна:

25.1.1.энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангах хөрөнгө оруулалтын арга хэрэгсэл;

25.1.2.энэ хуулийн 26.1-д заасан хөрөнгийн ангилал бүрд болон нэг этгээд, эсхүл хэд хэдэн этгээдэд хөрөнгө оруулалт хийх дээд хязгаар;

25.1.3.хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах журам;

25.1.4.хөрөнгө оруулалтын эрсдэлийг үнэлэх, удирдах, хянах журам;

25.1.5.хөрөнгө оруулалтын бодлогод өөрчлөлт оруулах аргачлал.

25.2.Хорооноос тогтоосон журмын дагуу хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч хөрөнгө оруулалтын бодлого болон эрсдэлийн удирдлагын бодлогыг нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдаж байгаа гишүүнд танилцуулна. Бодлогод оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Хороо болон гишүүнд тухай бүрд мэдэгдэнэ.

26 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын ангилал

.1.Нэмэлт тэтгэврийн хөрөнгөөр дараах хөрөнгө оруултад хөрөнгө оруулна:

.1.1.Төв банк /Монголбанк/-наас тавьсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангасан банкны системд нөлөө бүхий банкны мөнгөн хадгаламж, хадгаламжийн сертификат;

.1.2.Засгийн газрын үнэт цаас, аймаг, нийслэлийн үнэт цаас, Засгийн газрын өрийн баталгаа бүхий үнэт цаас, Төв банк /Монголбанк/-ны үнэт цаас;

.1.3.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан Монгол Улсын нутаг дэвсгэрт нийтэд санал болгон гаргасан дотоодын болон гадаадын үнэт цаас гаргагчийн үнэт цаас;

.1.4.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үүсмэл санхүүгийн хэрэгсэл, хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, биржийн бус зах зээлд арилжаалагддаг үнэт цаас;

26.1.5.Гадаад улсын банкны мөнгөн хадгаламж, хадгаламжийн сертификат, үнэт цаас.

26.2.Хороо нэг үнэт цаас гаргагч, түүний холбогдох хуулийн этгээд болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн нийт гаргасан үнэт цаас, банкны хадгаламж, хадгаламжийн сертификатад хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн эзэмшиж болох дээд хязгаарыг тогтооно.

26.3.Нэмэлт тэтгэврийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгөөр зээл, барьцаа, баталгаа, батлан даалт гаргахыг хориглоно.

27 дугаар зүйл.Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх

27.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь дараах этгээдийн гаргасан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийхийг хориглоно:

27.1.1.тухайн хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч болон тэдгээрийн толгой, охин, хараат, зэргэлдээ компани;

27.1.2. тухайн хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан болон тэдгээрийн холбогдох этгээдийн дангаар, эсхүл хамтдаа эзэмших хувьцааны хяналтын багц эзэмшдэг компани, хөрөнгө оруулалтын сан болон хуулийн этгээд;

27.1.3. тухайн хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодианы нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон тэдгээрийн холбогдох этгээдийн дангаар, эсхүл хамтдаа эзэмших хувьцааны хяналтын багц эзэмшдэг компани, хөрөнгө оруулалтын сан болон хуулийн этгээд.

27.2. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид үйлчилгээ үзүүлэх кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн холбогдох этгээд байхыг хориглоно.

27.3. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компани хууль зөрчиж, ашиг сонирхлын зөрчил бүхий гэрээ, хэлцэл байгуулахыг хориглоно.

28 дугаар зүйл. Кастодиан

28.1. Кастодиан Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон нэмэлт тэтгэврийн хөрөнгөтэй холбоотой дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

28.1.1. нэмэлт тэтгэврийн хөрөнгөөр хөрөнгө оруулсан үнэт цаас, хадгаламжийн сертификатыг хадгалах, гүйлгээг бүртгэх;

28.1.2. нэмэлт тэтгэврийн хөрөнгөтэй холбоотой мэдээллийг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид цахим, эсхүл цаасан хэлбэрээр өгөх;

28.1.3. нэмэлт тэтгэврийн хөрөнгөтэй холбоотой хийсэн гэрээ, хэлцэл нь энэ хууль болон холбогдох хууль тогтоомж, хөрөнгө оруулалтын бодлогод нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;

28.1.4. хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчаас өгсөн үүрэг даалгаварыг энэ хууль болон холбогдох хууль тогтоомж, хөрөнгө оруулалтын бодлого болон гэрээнд нийцүүлэн биелүүлэх;

28.1.5. нэмэлт тэтгэврийн хөрөнгөөр энэ хууль болон холбогдох хууль тогтоомж, хөрөнгө оруулалтын бодлогод нийцүүлэн хөрөнгө оруулалт хийсэн эсэхэд хяналт тавих, зөрчил гарсан тохиолдолд Хороо, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид мэдэгдэх;

28.1.6. хөрөнгө оруулалтын менежментийн компанийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

28.1.7. кастодианы гэрээнд заасан үүрэг болон Хорооноос баталсан бусад дүрэм, журмын хэрэгжилтийг хангах.

28.2. Кастодиан нь хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчтай Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 50.1-д заасны дагуу гэрээ байгуулна

28.3.Гэрээ байгуулсан кастодиан энэ хууль болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасан эрх, үүргийг эдлэх бөгөөд энэ хуульд заасан итгэмжлэгдсэн өмчлөгч байна.

28.4.Кастодиан нь нэгээс дээш тооны хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид үйлчилгээ үзүүлж болно. Энэ тохиолдолд нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө, үйл ажиллагаа, бүртгэл мэдээллийг тус тусад нь бүртгэнэ.

28.5.Кастодиан нь үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл шаардлагыг хангасан хуулийн этгээд байна.

28.6.Кастодиантай байгуулсан гэрээгээр энэ хуульд заасан кастодианы үүрэг хариуцлагыг хязгаарлахыг хориглоно.

28.7.Кастодиан нь хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчийн өмнө хүлээсэн өөрийн итгэмжлэгдсэн өмчлөгчийн үүргийг зөрчвөл энэ хууль, бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

28.8.Нэмэлт тэтгэврийн хөрөнгийг кастодианы хөрөнгөөс тусгаарласан байна.

30 дугаар зүйл.Кастодианд хориглох зүйл

30.1.Кастодиан нэмэлт тэтгэврийн хөрөнгөөр үйл ажиллагаа эрхлэхэд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд зааснаас гадна дараах зүйлийг хориглоно:

30.1.1.хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйлчилгээ үзүүлэх;

30.1.2.хөрөнгө оруулалтын менежментийн компани, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, тэдгээрийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, холбогдох этгээд байх;

30.1.3.хөрөнгө оруулалтын менежментийн компани, түүний холбогдох этгээд, ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хувьд тухайн ажил олгогчид зээл олгох, зээл авах.

30.2.Кастодианы холбогдох этгээдэд энэ хуулийн 30.1.1 дэх заалт мөн адил хамаарна.

32 дугаар зүйл.Кастодианы үйл ажиллагаанд тавих хяналт

32.1.Эрх бүхий байгууллагаас кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, кастодиан гэрээний үүргийг зөрчсөн дампуурсан эсхүл татан буугдсан бол хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч дараах арга хэмжээг авна:

32.1.1.кастодианд гэрээ цуцлах тухай мэдэгдлийг ажлын 2 өдрийн дотор хүргүүлж Хороонд энэ тухай мэдэгдэх;

32.1.2.шинэ кастодианыг ажлын 2 өдрийн дотор томилох.

32.2.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч энэ хуулийн 32.1.1, 32.1.2-т заасан хугацаанд арга хэмжээ аваагүй бол Хорооноос кастодианыг өөрчлөхийг үүрэг болгоно.

32.3.Хороо кастодианы бүтэц болон санхүүжилтийн доголдол үүссэн талаар хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, Төв банк /Монголбанк/-анд ажлын нэг өдрийн дотор мэдэгдэнэ. Төв банк /Монголбанк/ кастодианы доголдол үүссэн талаар Хороо, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид мэдэгдэнэ.

32.4.Кастодианыг өөрчлөхдөө нэмэлт тэтгэврийн хөрөнгөтэй холбоотой кастодианы үйл ажиллагаа тасралтгүй үргэлжлэхээр тооцож хэрэгжүүлнэ.

32.5.Кастодиантай байгуулсан гэрээ дуусгавар болсон бол кастодиан өөрийн хадгалалт хамгаалалтад байсан үйлчилгээтэй холбоотой нэмэлт тэтгэврийн хөрөнгө болон бүх баримт бичгийг шинээр томилогдсон кастодианд анх байгуулсан кастодианы үйлчилгээний гэрээнд заасан хугацаанд эсхүл талуудын харилцан тохиролцсон хугацааны дотор хүлээлгэн өгнө.

32.6.Энэхүү хуулийн 32.5-д заасан баримт бичиг болон нэмэлт тэтгэврийн хөрөнгө бүрэн шилжих хүртэл кастодиан үүрэг хариуцлагаа үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

32.7.Кастодиан нь энэ хууль, бусад хууль тогтоомж зөрчсөн эсхүл зөрчих боломжтой гэж үзсэн, эсхүл гишүүний ашиг сонирхолд эрсдэл үүсгэсэн үйлдэл, эс үйлдлийг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, Хороонд ажлын нэг өдрийн дотор мэдэгднэ.

32.8.Энэ хуульд заасны дагуу кастодиан үйлчилгээнд байршуулсан нэмэлт тэтгэврийн хөрөнгө нь кастодианы хөрөнгөд тооцогдохгүй бөгөөд кастодиантай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шийдвэр гүйцэтгэл, дампуурлын хэрэг, эвлэрэл түүнтэй адилтгах бусад ажиллагаанд хамаарахгүй.

33 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын менежментийн компани

33.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь нэмэлт тэтгэврийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын менежментийн компаниар итгэмжлэн удирдуулна.

33.2.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь нэг болон хэд хэдэн хөрөнгө оруулалтын менежментийн компанийг сонгож болно.

33.3.Нэмэлт тэтгэврийн хөрөнгийг энэ хуулийн 26.1.1, 26.1.2-т заасан хөрөнгийн ангилалд Хорооноос тогтоосон дээд хязгаарт багтаан хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь хөрөнгө оруулж итгэмжлэн удирдаж болно.

33.4.Итгэмжлэн удирдах нэмэлт тэтгэврийн хөрөнгө нь хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хөрөнгөд тооцогдохгүй бөгөөд хөрөнгө оруулалтын менежментийн компанитай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шийдвэр гүйцэтгэл, дампуурлын хэрэг, эвлэрэл түүнтэй адилтгах бусад ажиллагаанд хамаарахгүй.

33.5.Хөрөнгө оруулалтын менежментийн компани хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн өмнөөс хувьцаанд ногдох саналын эрхийг хэрэгжүүлэхдээ

зөвхөн гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчийн эрх ашгийг хамгаалах зорилготой байна.

33.6.Хөрөнгө оруулалтын менежментийн компани энэ хуулийн 33.5-д зааснаар санал өгөхдөө хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид мэдэгдэх ба өгсөн саналаа үндэслэлтэй болохыг нотолно.

34 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын менежментийн компанид тавигдагдах шалгуур

34.1.Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь дараах шалгуурыг хангасан байна:

34.1.1.албадлагын ямар нэгэн арга хэмжээ авагдаагүй, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлээгүй, хүчингүй болгоогүй байх;

34.1.2.кастодиан, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хувьд тухайн ажил олгогчийн холбогдох этгээд, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч эсхүл холбогдох этгээд биш байх.

34.1.3.сүүлийн нэг жилээс доошгүй хугацаанд сангийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу удирдсан байх.

34.2.Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь кастодиан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, тэдгээрийн холбогдох этгээд, ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хувьд ажил олгогчид зээл олгох, тэдгээрээс зээл авахыг хориглоно.

35 дугаар зүйл.Нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компанитай байгуулах гэрээ

35.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн хөрөнгө оруулалтын менежментийн компанитай дараах агуулгыг тусгасан хөрөнгө оруулалтын менежментийн гэрээ байгуулна:

35.1.1.хөрөнгө оруулалтын менежментийн компанийн эрх, үүрэг, хариуцлага;

35.1.2.хувьцааны саналын эрхийг хэрэгжүүлэх зааварчилгаа;

35.1.3.хөрөнгө оруулалтын менежментийн компанид төлөх хөлсийг тогтоож, түүний зардал, төлбөрийг хөрөнгө оруулалтын менежментийн удирдаж буй нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хэдэн хувиар тооцоолох аргачлал;

35.2.Энэ хуулийн 35.1-д заасан гэрээнд хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг гэрээ байгуулсан кастодианаар дамжуулан хэрэгжүүлэхээр заана.

36 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах

36.1.Нэмэлт тэтгэврийн хөрөнгийг хамгаалах, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх, хуульд заасан бусад шаардлагыг хангах зорилгоор хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, хөрөнгө оруулалтын менежментийн компани нь дараах тохиолдолд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах арга хэмжээг авна:

36.1.1.хөрөнгө оруулалт хийсэн этгээдийн байгууллагын бүтэц болон үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт орох;

36.1.2.хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хянах боломжгүй нөхцөл байдал үүсэх.

36.2.Хороо хөрөнгө оруулалттай холбоотой зөрчил илэрсэн өдөр, хөрөнгө оруулалтын ангилал бүрд хөрөнгийн үнэлгээ хийж тухайн зөрчил илэрснийг тогтоосон өдрөөс хойш гурван сар хүртэл хугацааны дотор энэ хуульд нийцүүлэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд өөрчлөлт оруулна.

ТАВДУГААР БҮЛЭГ ГИШҮҮН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ХӨТӨЛБӨР ХООРОНД ШИЛЖИХ, ХӨТӨЛБӨРИЙГ ДУУСГАВАР БОЛГОХ

37 дугаар зүйл.Гишүүн хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хооронд шилжих

37.1.Гишүүн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хооронд шилжиж болно.

37.2.Нэмэлт тэтгэврийн гэрээ, журамд нэмэлт тэтгэврийн хөрөнгийг шилжүүлэх нөхцөл, шаардлагыг тусгана.

37.3.Гишүүн хөтөлбөр хооронд шилжих хүсэлтээ хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид бичгээр мэдэгдэнэ.

37.4.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч энэ хуулийн 37.3-т заасны дагуу мэдэгдсэнээс хойш ажлын 10 өдрийн дотор гишүүний нэрийн дансны хөрөнгийг холбогдох зардлыг суутгаж, шилжүүлнэ.

37.5.Гишүүн нэмэлт тэтгэврийн хөрөнгөө өөр хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид шилжүүлэхэд татвар ногдуулахгүй.

37.6.Гишүүн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хооронд шилжихтэй холбогдсон журмыг Хороо батална.

38 дугаар зүйл.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг дуусгавар болгох

38.1.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөр дараах тохиолдолд дуусгавар болно:

38.1.1.энэ хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу шилжсэн;

38.1.2.энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан төрлөөр авч дууссан;

38.1.3.гишүүн, эрх залгамжлагч, өвлөгч нас барсан;

ЗУРГААДУГААР БҮЛЭГ НЭМЭЛТ ТЭТГЭВЭР ОЛГОХ

39 дүгээр зүйл.Нэмэлт тэтгэврийн эрх үүсэх, төрөл, олгох нөхцөл

39.1.Гишүүн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэврийн насанд хүрсэн, хөдөлмөрийн чадвар бүрэн алдсан тохиолдолд нэмэлт тэтгэвэр тогтоолгох эрх үүснэ.

39.2.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрөөс тэтгэвэр тогтоолгох эрхтэй гишүүн дараах төрлийн нэмэлт тэтгэврийн аль нэгийг, эсхүл хослуулан зөвхөн 1 удаа сонгоно:

39.2.1.нэг удаагийн тэтгэвэр;

39.2.2.хуваарьт тэтгэвэр;

39.2.3.насан туршийн тэтгэвэр.

39.3.Нэг удаагийн тэтгэврийн дээд хязгаарыг нэмэлт тэтгэврийн журам, гэрээнд тусгасан байх бөгөөд нийт дүнгээр эсхүл гишүүний нэмэлт тэтгэврийн хуримтлалын тодорхой хувиар тогтооно.

Тайлбар: “нэг удаагийн тэтгэвэр” гэж нэмэлт тэтгэврийн хөрөнгийг тэтгэврийн нэрийн данснаас гишүүнд нэг удаа олгох мөнгөн дүнг хэлнэ.

39.4.Гишүүнд хуваарьт тэтгэврийг 5-10 хүртэл жилийн хугацаанд олгох бөгөөд аргачлалыг нэмэлт тэтгэврийн гэрээ, журамд заана.

Тайлбар: “хуваарьт тэтгэвэр” гэж гишүүнд нэмэлт тэтгэврийн хөрөнгийг тодорхой хуваарийн дагуу тогтсон дүнгээр тэнцүү олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

39.5.Насан туршийн тэтгэвэрт хамрагдахад шаардагдах тэтгэврийн нэрийн дансны хадгалагдсан эрхийн доод хязгаарыг тэтгэврийн журам, гэрээгээр тогтооно.

Тайлбар: “насан туршийн тэтгэвэр” гэж гишүүний тэтгэврийн наснаас хойш нэмэлт тэтгэвэр авах хугацааны илэрхийлэлд үндэслэн тооцож, нас барах хүртэл хугацаанд сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

39.6.Гишүүн энэ хуулийн 39.2.2, 39.2.3-т заасны дагуу тэтгэвэр авах бол урт хугацааны даатгагчтай гэрээ байгуулна. Гэрээнд олгох тэтгэврийн хэмжээ, хугацаа, нас барсны дараа үүсэх өвийн зохицуулалтыг заавал тусгана.

39.7.Гишүүн энэ хуулийн 39.2.2, 39.2.3-т заасны дагуу тэтгэвэр авах бол хувийн тэтгэврийн сан урт хугацааны даатгагчтай гэрээ байгуулж нэмэлт тэтгэврийн хөрөнгийг шилжүүлнэ.

40 дүгээр зүйл.Эрх залгамжлагч, өвлөгчид хадгалагдсан эрх, хөрөнгийг шилжүүлэх

40.1.Гишүүн тэтгэвэрт гарахаас өмнө нас барсан бол хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч гишүүний нэмэлт тэтгэврийн хөрөнгийг эрх залгамжлагчийн нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд шилжүүлнэ.

40.2.Гишүүн нь эрх залгамжлагчийг нэрлээгүй, эрх залгамжлагч нь нас барсан тохиолдолд өвлөгчид нэмэлт тэтгэврийн хөрөнгийг өвлөгчийн нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд шилжүүлнэ.

40.3.Иргэний эрх зүйн чадамжгүй, иргэний эрх зүйн чадамжаа хязгаарлуулсан эрх залгамжлагч, өвлөгчийн хувьд асран хамгаалагч, эсхүл харгалзан дэмжигч нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн гэрээ хийж, нэмэлт тэтгэврийн нэрийн данс нээнэ.

Нэмэлт тэтгэврийн хөрөнгийг эрх залгамжлагч, өвлөгчид энэ хуульд заасны дагуу зарцуулна.

40.4.Эрх залгамжлагч, өвлөгч гишүүний амь насыг хохироосон нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон бол тухайн эрх залгамжлагч, өвлөгчид нэмэлт тэтгэврийн хөрөнгийг шилжүүлэхгүй.

40.5.Энэ хуулийн 40.4-т заасан тохиолдолд гишүүн эрх залгамжлагчийг нэрлээгүй, хууль ёсны өвлөгч байхгүй бол хувийн тэтгэврийн нэрийн дансанд хуримтлагдсан хөрөнгийг төрийн өмчлөлд шилжүүлнэ.

41 дүгээр зүйл.Нэмэлт тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг

41.1.Гишүүн, эрх залгамжлагч, өвлөгч нэмэлт тэтгэвэр тогтоолгоход дараах баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид гаргана:

41.1.1.тэтгэврийн төрлийг сонгож, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн баталсан маягтын дагуу гаргасан хүсэлт;

41.1.2.тэтгэвэр хүлээн авах банкны нэр, дансны дугаар;

41.1.3.эрх залгамжлагч нэрлэгдээгүй тохиолдолд өвлөгч, эсхүл өвлөгчийг тогтоосон баримт бичиг;

41.1.4.шаардлагатай тохиолдолд гишүүний хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсаныг нотлох баримт бичиг;

42 дугаар зүйл.Нэмэлт тэтгэвэр тогтоох, олгох, өргөдөл шийдвэрлэх хугацаа

42.1.Гишүүн, эрх залгамжлагч, өвлөгч баримт бичиг бүрдүүлж, хүсэлт гаргаснаас хойш хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч ажлын 10 өдрийн дотор нэмэлт тэтгэврийн хэмжээг тогтоож, сонгосон арилжааны банкны дансанд бэлэн бусаар шилжүүлнэ.

42.2.Гишүүн насан туршийн тэтгэвэр авахаар тохирсон, тэтгэврийн асуудлыг шийдвэрлэхэд нэмэлт хугацаа шаардлагатай бол хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч энэ хуулийн 42.1-д заасан хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж, энэ тухай гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчид мэдэгдэнэ.

42.3.Энэ хуульд заасан хугацаанд хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч шийдвэр гаргаагүй бол гишүүн, эрх залгамжлагч, өвлөгч нь хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид гомдол гаргах эрхтэй. Хэрэв шийдвэрийг эс зөвшөөрвөл Хороонд энэ хуульд заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

42.4.Хороо хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчаас гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчид нэмэлт тэтгэвэр тогтоох, олгох, баримт бичиг бүрдүүлэх, хянах, өргөдөл, гомдол шийдвэрлэх, үлдэгдэл хөрөнгийг шилжүүлэх харилцааг зохицуулсан журмыг батална.

ДОЛООДУГААР БҮЛЭГ
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТ, ТАЙЛАГНАЛ

43 дугаар зүйл.Нягтлан бодох бүртгэл

43.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэнэ.

44 дүгээр зүйл.Аудит, актуарын тайлан

44.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч жилийн санхүүгийн тайланд аудит хийлгэнэ.

44.2.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч жилийн санхүүгийн тайланд аудит хийлгэнэ.

44.3.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч аудитаар баталгаажсан жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлж, Хороонд хүргүүлнэ.

44.4.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөрөнгөнд актуарын тайлан, дүгнэлт гаргуулж, Хороонд хүргүүлнэ.

44.5.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт актуарын хяналт шалгалтыг хоёр жилд нэгээс доошгүй удаа актуарчаар хийлгэх бөгөөд актуарын хяналт шалгалтын тайланг Хороонд хүргүүлнэ.

44.6.Хороо актуарын хяналт шалгалтыг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн томилсон, эсхүл өөрийн томилсон актуарчаар гүйцэтгүүлж болно.

45 дугаар зүйл.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч үйл ажиллагаагаа тайлагнах

45.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь гишүүнд дараах тайланг тайлагнана:

45.1.1.нэмэлт тэтгэврийн хөрөнгийн бүх гүйлгээ, хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцоолж, тэтгэврийн нэрийн дансанд улирал тутамд оруулан бүртгэж, тэтгэврийн нэрийн дансны нийт үлдэгдлийг илтгэсэн тайлан;

45.1.2.гишүүн бүрд хөрөнгө оруулалтын бодлого, захиран зарцуулж байгаа тэтгэврийн нийт хөрөнгө, хөрөнгө оруулалтын үр дүн, тэтгэврийн нэрийн дансны дэлгэрэнгүй мэдээлэл дараа жилийн эхний улиралд багтаан цаасан, эсхүл цахим хэлбэрээр.

45.2.Энэ хуулийн 45.1-д заасан мэдээлэлтэй цахим хэлбэрээр танилцах, хянах боломжийг бүрдүүлж, гишүүнийг нэвтрэх эрхээр хангана.

45.3.Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах ажилтан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан өөрчлөгдсөн, хөрөнгө оруулалтын бодлогод өөрчлөлт орсон тохиолдолд гишүүнд тухай бүр мэдэгдэнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

46 дугаар зүйл.Мэдээллийн нэгдсэн сан

46.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь гишүүн, эрх залгамжлагч, өвлөгч, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбогдсон цахим мэдээллийн нэгдсэн сантай байна.

46.2.Мэдээллийн сан нь гишүүний дараах мэдээллийг агуулсан байна:

46.2.1.гишүүний төлсөн шимтгэлийн мэдээлэл;

46.2.2.баталгаат өгөөж, хөрөнгө оруулалтын бодит болон тооцоолсон өгөөж;

46.2.3.нэмэлт тэтгэврийн хөрөнгийг шилжүүлэх, өвлүүлэхээр гаргасан хүсэлтийн мэдээлэл;

46.2.4.олгосон тэтгэвэр;

46.2.5.хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хоорондын шилжилт;

46.2.6.гишүүний эрх залгамжлагч, өвлөгчийн мэдээлэл, тэдгээрт төлөгдсөн мөнгөн дүн;

46.2.7.хөдөлмөрийн чадвар алдалтын талаар;

46.2.8.суутгасан татвар, татвар төлөлт;

46.2.9.кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн мэдээлэл;

46.3.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах бөгөөд сангийн мэдээллийг 70 дээш жил хадгална.

46.4.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн мэдээллийн сангийн нууцлалыг хадгалах бөгөөд зөвхөн эрх бүхий байгууллага, гишүүн, эрх залгамжлагч, өвлөгч нэвтрэх эрхтэй байна.

46.5.Эрх бүхий байгууллага нь зөвхөн хяналт тавих, шалгалт хийх, гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчийн гомдлыг барагдуулах зорилгоор мэдээллийн санг ашиглах эрхтэй.

46.6.Хороо энэ хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, шалгалт хийх, тайлагнах, судалгаа хийх зорилгоор мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж ашиглана.

46.7.Хороо нэмэлт тэтгэврийн хөтөлбөр болон тэтгэврийн нэрийн дансны мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлт, ашиглалт, аюулгүй байдал, мэдээлэл сэргээх, мэдээллийн нууцлалтай холбоотой дүрмийг батална.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

47 дугаар зүйл.Итгэмжлэгдсэн өмчлөгч үүрэг зөрчих, хариуцлага хүлээлгэх

47.1.Итгэмжлэгдсэн өмчлөгч нэмэлт тэтгэврийн хөрөнгийг итгэмжлэлийн хүрээнд зөвхөн гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчийн ашиг сонирхолд нийцүүлэн

итгэмжлэн удирдана. Бусад зорилгоор үйл ажиллагаа явуулсан бол итгэмжлэгдсэн өмчлөгчийг үүргээ зөрчсөнд тооцно.

47.2.Итгэмжлэгдсэн өмчлөгч өөртөө, өөрийн холбогдох этгээд, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, холбогдох бусад этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн нэмэлт тэтгэврийн хөрөнгийг захиран зарцуулсан бол итгэмжлэгдсэн өмчлөгчийн үүргээ зөрчсөнд тооцно.

47.3.Энэ хуульд тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдолд нөгөө этгээд нь итгэмжлэгдсэн өмчлөгчийн холбогдох этгээд, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, холбогдох этгээд байхад тэдгээртэй нэмэлт тэтгэврийн хөрөнгөөр гүйлгээ хийсэн бол итгэмжлэгдсэн өмчлөгчийн үүргээ зөрчсөнд тооцно.

47.4.Итгэмжлэгдсэн өмчлөгч нөгөө итгэмжлэгдсэн өмчлөгч зөрчил гаргасныг мэдсэн эсхүл мэдэх боломжтой байсан бол итгэмжлэгдсэн өмчлөгчийн зөрчилд мөн адил хариуцлага хүлээнэ.

47.5.Итгэмжлэгдсэн өмчлөгчийн үүрэг хариуцлагыг зөрчсөн ажилтны зөрчилд ажил олгогч мөн хариуцлага хүлээнэ.

47.6.Итгэмжлэгдсэн өмчлөгчийн зөрчилд хүлээлгэх хариуцлагыг энэ хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

47.7.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн үйл ажиллагаа эрхэлж буй хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан, бусад итгэмжлэгдсэн өмчлөгчид нь хууль тогтоомж, гэрээ зөрчсөн тохиолдолд гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчийн итгэмжилсэн хөрөнгөд хариуцлага хүлээнэ.

47.8.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн итгэмжлэгдсэн өмчлөгчтэй холбогдсон иргэний маргааныг шийдвэрлэхдээ энэ хууль, бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хохирлыг төлүүлнэ.

47.9.Итгэмжлэгдсэн өмчлөгчийн хууль бус үйл ажиллагаанаас учирсан хохирлыг төлүүлэхээр гишүүн, эрх залгамжлагч, өвлөгч нь дараах шаардлагыг Хороо болон шүүхэд гаргаж болно:

47.9.1.гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчид ногдох нэмэлт тэтгэврийн хөрөнгийг бүхэлд нь олгуулах;

47.9.2.гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчийн бусад хохирлыг барагдуулах.

47.10.Итгэмжлэгдсэн өмчлөгч хүлээсэн үүрэг хариуцлагаа зөрчсөнөөс үүссэн бүх хохирлыг холбогдох гишүүн, эрх залгамжлагч, эсхүл өвлөгчийн нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд төлж барагдуулна.

48 дугаар зүйл.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөртэй холбоотой маргаан шийдвэрлэх

48.1.Нэмэлт тэтгэврийн журамд гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчийн гомдлыг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч шийдвэрлэх үйл ажиллагааг тусгана.

48.2.Хороо нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн үйл ажиллагаа бүртгэх журамд гомдол шийдвэрлэх нэгжийг бүрдүүлсэн эсэхийг хянана.

48.3.Гомдол шийдвэрлэх нэгж нь хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид гишүүнээс гаргасан гомдлыг ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

48.4.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн гомдол шийдвэрлэх нэгжид гомдол гаргасан гишүүн, эрх залгамжлагч, өвлөгч нь гарсан шийдвэрийг эс зөвшөөрвөл Хороонд гомдол гаргах эрхтэй.

48.5.Хороо нь хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, нэмэлт тэтгэврийн хөтөлбөртэй холбоотой гомдол шийдвэрлэх журмыг батална.

48.6.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь Хорооны гаргасан шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

48.7.Хорооны маргаан шийдвэрлэсэн шийдвэрийг эс зөвшөөрсөн гишүүн, эрх залгамжлагч, өвлөгч нь шүүхэд хандах эрхтэй.

48.8.Гишүүн урт хугацааны даатгагчийн төлөх насан туршийн тэтгэвэртэй холбоотой гомдлоо урт хугацааны даатгагч болон Хороонд гаргаж холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГИЙН ЧИГ ҮҮРЭГ

49 дүгээр зүйл.Хорооны чиг үүрэг

49.1.Хороо энэ хуулийн хэрэгжилтийг хангах, нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт шалгалт хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчийн эрх ашгийг хамгаалах, багц дүрэм, журам, заавар, аргачлал, удирдамж, маягт батлах, мөрдүүлэх нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

49.2.Хороо хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, нэмэлт тэтгэврийн хөтөлбөр, кастадион, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаанд энэ хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хяналт шалгалт хийнэ.

49.3.Хороо нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг тайлагнах журам, маягтыг батална.

49.4.Шаардлагатай тохиолдолд Хороо энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан арга хэмжээ авна.

50 дугаар зүйл.Татварын байгууллагын чиг үүрэг

50.1.Татварын байгууллага нь нэмэлт тэтгэврийн үйл ажиллагааны хүрээнд татвар чөлөөлөх, ногдуулах, төлүүлэх, хяналт тавих, ногдуулж, төлүүлсэн албан татварын мэдээллийг гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчид өгөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

51 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэг

51.1.Нийгмийн даатгалын байгууллага нийгмийн даатгалд даатгуулагчийн мэдээллийг эрх бүхий байгууллагаар дамжуулан хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид хүргүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

52 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

52.1.Монгол Улсад нэмэлт тэтгэврийн хөтөлбөртэй ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлж байсан этгээд нь энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш нэг жил хүртэлх хугацаанд үйл ажиллагаагаа энэ хуульд нийцүүлнэ.

52.2.Хороо энэ хуульд заасан дүрэм, журам, бусад шаардагдах бичиг баримтыг энэ хууль батлагдсанаас хойш зургаан сар хүртэлх хугацаанд боловсруулж батална.

53 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

53.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

53.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд энэ хууль, Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

54 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

54.1.Энэ хуулийг 20... оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.